

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2024.03.12

Сайншанд

№	Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4
Судалгаа, мэдээ тайлан гаргах ажлын хүрээнд			
1	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг www.mrpm.gov.mn цахим хуудсаар дамжуулан шинэчлэх	<p>Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний мэдээг сар бүр гаргаж гаргаж сумд Засаг дарга нар болон холбогдох мэргэжилтэн, Цагдаа, Мэргэжлийн Хяналт, Байгаль орчин, аялал жуулчлалын газар зэрэг төрийн байгууллагуудыг мэдээ мэдээллээр хангаж хуулийн хэрэгжилтийг хангуулж ажилласан.</p> <p>Аймгийн хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар 356 тусгай зөвшөөрөл нийт нутаг дэвсгэрийн 9.2 хувьд ашигт малтмалын ашиглалтын 214 тусгай зөвшөөрөл, хайгуулын 142 тусгай зөвшөөрөл, түгээмэл тархацтай ашигт малтмалын 9, хайгуулын 11 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр бүртгэлтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад ашиглалтын талбай 1-ээр, хайгуулын талбай 17-оор, талбайн хэмжээ 0,1 хувиар тус тус нэмэгдсэн.</p> <p>Тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний мэдээллийг сар бүр гаргаж сумдын Засаг дарга нарыг мэдээллээр ханган ажилласан.</p>	100
2	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, өөрчлөлт, тайлан, зардлын 50%-ийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалт, буцаан төлөлтийн мэдээ, тайланг компани тус бүрээр гаргаж, дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн Дэд зөвлөлийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор түүний үйл ажиллагаанд 500,0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.	100
3	Орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр хандив, дэмжлэгийн мэдээг гарган, санхүү татварын мэдээлэлтэй тулган баталгаажуулсны үндсэн дээр программд шивж оруулан нэгдсэн дүнг ОУИТБСА-ын албанд хүргүүлэх	Аймгийн нутаг дэвсгэрт 2022 онд уул уурхай ашигт малтмалын олборлолт, боловсруулах үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулсан 107 аж ахуй нэгжийн 2753803908.1 төгрөгийн татвар, хураамж, төлбөр төсөвт төвлөрч, 23 аж ахуйн нэгжээс үзүүлсэн хандив тусламжийн тайланг www.e-reporting.eitimongolia.mn бүртгэн оруулж Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын албанд хүргүүлсэн.	100
4	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийн мэдээ тайлан	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, түүний эхний үеийн болон "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд "Нээлттэй	100

	гаргах, Гэрээний ил тод байдлын цахим санд шинээр байгуулсан гэрээг оруулах	Дорноговь" чуулганы хүрээнд уул уурхайн зөвлөгөөнийг зохион байгуулж, уул уурхайн ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 110 аж ахуйн нэгж, байгууллагын 211 төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. Зөвлөгөөний үеэр уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, биологийн төрөл зүйлийг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлэн 3 талт "Хамтран ажиллах гэрээ"-г "Монцемент билдинг материалс" ХХК, "Говийн шандаст хүлэг" ХХК, "Фриендшип ресурс" ХХК, "Билэгт баялаг" ХХК, "Талст дөл" ХХК, "Олон ихт баян" ХХК, "Си Өү Эй Эл" ХХК, "Монголросцветмет"ТӨҮГ, "Доншен газрын тос /Монгол/" ХХК, "Түмэн айл инвест" ХХК зэрэг 10 компанитай байгуулсан. Гэрээний дагуу орон нутгаас шаарлагатай 3000 гаруй иргэн ажлын байраар хангагдсан. Дээрх уул уурхайн компаниудтай байгуулсан Хамтран ажиллах 10 гэрээг байгуулж www.iltodgerее.mn сайтад байршуулсан.	
Иргэдэд нээлттэй ил тод мэдээллэх, олон талын оролцоотой хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хүрээнд			
1	2023 онд орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татвар, төлбөр, хураамжийн орлогын тайланг аймгийн dornogovi.gov.mn цахим хуудас болон сонин, сэтгүүл, мэдээ байршуулж нийтэд мэдээлэх	Орон нутагт хэрэгжиж буй уул уурхай түүнийг дагасан төмөр зам, автозамын салбарын томоохон бүтээн байгуулалтын ажлын талаарх 6 удаагийн мэдээллийг орон нутгийн телевиз болох Dtv-ээр нэвтрүүлэг бэлтгэн иргэдэд мэдээлэл хүргэсэн. 2023 онд орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татвар, төлбөр, хураамжийн орлогын тайланг олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэх ажил хийгдээгүй. Аймгийн Засаг даргын "Хөгжлийн төлөө ХАМТДАА" 2 үйл ажиллагааны хөтөлбөрийн тайланг хэвлэмэл байдлаар гарган олон нийтэд тайлагнахаар эх бэлтгэлийн ажлыг гүйцэтгэх ажил хийгдэж байгаа бөгөөд уг тайланд уул уурхайн салбараас орон нутагт төвлөрүүлсэн төлбөр, хураамж, хандив дэмжлэгийн мэдээллийг тусгасан.	100
Хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, чадавхи бэхжүүлэх ажлын хүрээнд			
1	Сумдын ОУИТБС-ыг хэрэгжүүлэх дэд зөвлөлийг чадавхжуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулах	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын албанаас зохион байгуулсан цахим 2 удаагийн сургалтад дэд зөвлөлийн 4 гишүүн, танхимын сургалтад 2 гишүүн тус тус хамрагдсан. Уул уурхай хүнд, үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан 4 танхимын болон цахим сургалтуудад Уул уурхай, Газрын тос, хийн хяналтын улсын байцаагч нар хамрагдсан	80
2	"Нээлттэй Дорноговь аймаг чуулган"-д Уул уурхайн компаниудыг оролцуулж, уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулахад хамтран ажиллах	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, түүний эхний үеийн болон "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд "Нээлттэй Дорноговь" чуулганы хүрээнд уул уурхайн зөвлөгөөнийг зохион байгуулж, уул уурхайн ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 110 аж	100

		ахуйн нэгж, байгууллагын 211 төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. Дээрх зөвлөгөөнөөр улс, орон нутгаас уул уурхайн салбарт хэрэгжүүлж буй бодлого шийдвэрүүд, түүний хэрэгжилтийн талаар хэлэлцэж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилго бүхий томоохон арга хэмжээг танилцуулсан.	
НИЙТ ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ			97.1

ТАЙЛАН ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙ ИЛ
ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН ДЭД ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА



Г.МАРТ

ТАЙЛАН ГАРГАСАН:

АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД
БАЙДЛЫН САНААЧИЛГЫН ДЭД ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Х.ОТГОНЖАРГАЛ